

# ТОЙМ

---



**ОЛОН УЛСЫН  
ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ**

2024.09.09

*Голомт Капитал ҮЦК-д бэлтгэв*

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- АНУ-д ажилгүйдэл 4.2%-д хүрч буурч байгаа ажлын байрны өсөлт бага хэвээр байна.
- Dell болон Palantir-ын хувьцаанууд S&P500 индекст багтана.
- JPMorgan: Хятадын хувьцааг худалдан авах зөвлөмжөө цуцалж, шинэ тарифын дайн гарах эрсдэлтэйг анхааруулав.
- Хятадын үл хөдлөх хөрөнгийн борлуулалт өмнөх оныхоос 26.8%-иар буурчээ.
- БНХАУ-ын Hang Seng Индекс болон АНУ-ын S&P 500 индексүүд техникийн хувьд 5.0-6.0% уналт үзүүлэх боломжтой байна.

2024 он 9-р сарын 9

Dow Jones	40,345.41
S&P 500	5,408.42
Nasdaq	16,690.83
DAX	18,301.90
FTSE 100	8,181.47
S&P/ASX 200	8,013.4
HANG SENG	17,444.3

АНУ-ын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
Dow Jones	-1.01%	-2.93%	2.15%	7.05%	16.68%	16.58%
S&P 500	-1.73%	-4.25%	1.20%	13.39%	21.33%	21.30%
Nasdaq	-2.55%	-5.77%	-0.33%	11.19%	21.29%	10.42%

2024 оны 9 сарын 9-ны 11:00



Европын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
DAX	-1.48%	-3.32%	3.27%	9.25%	16.24%	17.25%
FTSE 100	-0.73%	-2.18%	0.16%	5.80%	9.40%	16.39%

2024 оны 9 сарын 9-ны 11:00



Ази Номхон далайн индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
S&P/ASX 200	-0.56%	-1.76%	2.44%	4.96%	11.33%	7.57%
Hang Seng	-1.82%	-3.26%	0.14%	0.40%	-5.97%	-34.69%

2024 оны 9 сарын 9-ны 11:00





## Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

### Өнгөрсөн долоо хоногт зах зээл уналттай байлаа

S&P 500 сүүлийн жил хагаст болсон хамгийн гүнзгий уналтыг өнгөрөгч долоо хоногт үзүүлээд байна. Технологийн сектор тус уналтын эхэнд бичигдсэн бөгөөд салбарын түүчээлэгч компаниудын нэг болох Nvidia-ийн хувьцааны ханш 14 гаруй хувь буурсан байна. Түүнчлэн зах зээл дээр тус компанийг АНУ-ын хууль зүйн яам монополийн тухай хууль зөрчсөн байж болзошгүй хэмээн шалгаж байна гэсэн цуурхал тархаад байна. Түүнчлэн, Intel Corporation-ы хувьцааны ханш Dow Jones Industrial Average индексээс хасагдаж магадгүй гэсэн хүлээлтэд үндэслэн өнгөрсөн долоо хоногт мөн адилаар 14 орчим хувь буурсан байна. Мөн адилаар эрчим хүчний сектор газрын тосны ханш буурсантай холбогдуулан буурчээ. 2024 оны 9-р сарын 9-ны байдлаар WTI маркийн газрын тос 68 ам.долларын түвшин дээр арилжаалагдаж байгаа бол Brent төрлийн хувьд нэг баррель нь 72 гаруй ам.доллараар үнэлэгдэж байна. Энэхүү зах зээлийн уналтыг тайлбарлах шалтгаануудын дунд түүхэн ажиглалтаас харж үзэхэд дунджаар 9-р сар бусад саруудтай харьцуулбал хувьцааны хувьд харьцангуй их уналтыг үзүүлдэг ажиглалт орж байна.

### Нөгөө талаас бондын зах зээл идэвхээр дүүрэн долоо хоног болж өнгөрчээ

Өнгөрсөн долоо хоногийн Мягмар гарагт АНУ-ын Хөдөлмөрчдийн өдрийн дараа бондын зах зах зээл хөл хөдөлгөөн ихтэй байлаа. Тухайлбал, тус өдөр 27 компани 43 тэрбум ам.долларын үнэ бүхий бонд гаргасан бөгөөд тэдгээр нь ихэнхдээ төлөвлөснөөс илүү их хөрөнгө оруулагчдыг татаж чадсан байна. 2024 оны 9-р сарын 9-ны байдлаар АНУ-ын Засгийн газрын ихэнх бондын өгөөж 3.5-с 5 гаруй хувьтай байгаа бол Bank of America зэрэг компанийн бондын өгөөж 7.5 гаруй хувьтай байна.

### График 1: АНУ-ын S&P500 индексийн ханшийн таамаглал

abligun published on TradingView.com, Sep 09, 2024 12:14 UTC+8

S&P 500 Index, 1D, SP -05,507.33 +5,522.47 -5,408.43 -94.99 (-1.73%)



TradingView





## Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

**Хятадын хувьцааны зах зээлд уналт үргэлжилж байна.**

Өнгөрсөн долоо хоногт Шанхайн Composite индекс 2.69%-иар унаж, CSI 300 индекс 2.71%-иар буураад байна. Хонгконг дахь Hang Seng индекс мөн 3.03%-иар буурсан байна. Үүнтэй зэрэгцэн JPMorgan банкны зүгээс Хятадын хувьцааг худалдан авах зөвлөмжийг цуцалж, шинэ тарифын дайн гарах эрсдэлтэй байгааг анхаарууллаа.

**Хятадын үйлдвэрлэл уналттай хэвээр байна.**

БНХАУ-ын Үйлдвэрлэлийн PMI үзүүлэлт 8-р сард 49.1 болж, 50-аас доош байснаар эдийн засгийн өсөлт буурч байгааг харуулж байна. Үйлдвэрлэл болон барааны захиалгуудын уналт улам даамжирсан нь Хятадын эдийн засагт дарамт учруулж буй гол хүчин зүйл болж байна. Үүний зэрэгцээ, барилга болон үйлчилгээний PMI бага зэрэг өссөн боловч эдийн засгийн бүсчлэлийн тэнцвэргүй байдал үргэлжилж байгааг харуулж байна.

**Үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн эрэлт багасаж байна.**

Хятадын 100 шилдэг хөгжүүлэгчийн шинэ орон сууцны борлуулалтын хэмжээ 8-р сард жилийн өмнөхөөс 26.8%-иар буурсан нь үл хөдлөх хөрөнгийн зах зээлд эрэлт багассаар байгааг илтгэж байна. Энэ уналт нь 7-р сарын 19.7%-ийн бууралтаас хурдацтай байгаа бөгөөд үл хөдлөх хөрөнгийн салбарт нэмэлт дэмжлэгийн арга хэмжээ авах шаардлага гарах магадлал өндөр байна.

**Тайванийн технологийн салбар ба эдийн засаг нь БНХАУ-аас хамааралтай.**

Технологийн салбараас хэт хараат байдал эдийн засгийн эрсдэл дагуулж байна. Тайванийн нийт экспортын 60%-ийг технологийн бүтээгдэхүүн эзэлдэг. Экспортын 35%-ийг Хятад улс хүлээн авдаг. Мөн Тайвань эрчим хүчний 98%-ийг гаднаас авдаг бөгөөд цөмийн эрчим хүчийг зогсоох төлөвлөгөө нь эрчим хүчний хангамжийн асуудлыг улам хүндрүүлж байна

### График 2: Hang Seng индексийн ханшийн таамаглал




























# ЭНЭ ДОЛОО ХОНОГИЙН ОНЦЛОХ ТАЙЛАНГУУД

Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

E EARNINGS W WHISPERS									
Most Anticipated Earnings Releases									
for the week beginning September 02, 2024									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close
		 	 	 	 	 	 	 	 
				 	 	 	 	 	 
				 	 	 	 	 	 
				 	 	 	 	 	 
				 	 	 	 	 	 
				 	 	 	 	 	 
				 	 	 	 	 	 
				 	 	 	 	 	 
				 	 	 	 	 	 
						 	 	 	 
<a href="http://eps.sh/cal">http://eps.sh/cal</a>								© 2024 Earnings Whispers	

Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

E EARNINGS W WHISPERS									
Most Anticipated Earnings Releases									
for the week beginning September 09, 2024									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close
									
									
									
									
									
									
									
									
									
<a href="http://eps.sh/cal">http://eps.sh/cal</a>								© 2024 Earnings Whispers	